

БШУГ-ЫН ДАРГА БАТЛАВ Ч.ДРИУНАА



ДОРНОД АЙМГИЙН 4 ДҮГЭЭР АНГИЙН 2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН МОНГОЛ ХЭЛ ХИЧЭЭЛИЙН ШАЛГАЛТЫН ХУРААНГУЙ БЛЮПРИНТ

2024.05.01

АНГИ		4 ДҮГЭЭР АНГИ														Нийт даалгаврын тоо	Нийт даалгаврын оноо	Агуулгын эзлэх хувь		
ХУГАЦАА		60 МИНУТ																		
ДААЛГАВРЫН ХЭЛБЭР		СОНГОХ ДААЛГАВАР								ЗАДГАЙ ДААЛГАВАР										
Хи-чээл	АТБХ	Мэдлэг ойлголт		Чадвар		Хэрэглээ		Бүгд		Мэдлэг ойлголт		Чадвар		Хэрэглээ		Бүгд				
Монгол хэл	Унших	2	2	2	2			4	4			1	2			1	2	5	6	33%
	Бичих	2	2	1	1			3	3			1	3	1	5	2	8	5	11	33%
	Хэлзүй	1	1	2	2			3	3			2	4			2	4	5	7	33%
<b>Даалгаврын тоо/оноо</b>		<b>5</b>	<b>5</b>	<b>5</b>	<b>5</b>			<b>10</b>	<b>10</b>			<b>4</b>	<b>9</b>	<b>1</b>	<b>5</b>	<b>4</b>	<b>10</b>	<b>15</b>	<b>24</b>	
<b>Онооны эзлэх хувь</b>		<b>50</b>		<b>50</b>				<b>100</b>				<b>64</b>		<b>36</b>		<b>100</b>		<b>60%</b>		<b>100%</b>

ҮНЭЛГЭЭНИЙ ЖИН

Үнэлгээний зорилт	Даалгаврын тоо	Эзлэх хувийн жин
Мэдлэг, ойлголтыг үнэлэх даалгавар	5	33%
Мэдлэгээ хэрэглэх чадварыг үнэлэх даалгавар	10	66%

БОЛОВСРУУЛСАН: БШУГ-ЫН БАГА БОЛОВСРОЛЫН МЭРГЭЖИЛТЭН

М.ХЭРЛЭНТУЯА

ДОРНОД АЙМГИЙН 8 ДУГААР СУРГУУЛИЙН 4 ДҮГЭЭР АНГИЙН **МОНГОЛ ХЭЛ  
ХИЧЭЭЛИЙН ШАЛГАЛТЫН СЭДЭВ**

**НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. УНШИХ**

**А ХУВИЛБАР**

**Ховдог чоно**

Төөтгөөхөн хүү төө халзан бяруугаа унаад , балт сүхээ бүсэндээ хавчуулаад, түлээ бэлдэхээр ойн захад очжээ. Гэтэл гай газар доороос гахай модон дотроос гэгчээр өлөн чоно гарч ирээд:

- Ходоод гэдэс минь хоосон болохоор хоёр бөөр минь хонхос хонхос хийж байна. Чамайг иднэ гэжээ.

- Ачит буурал чоно гуай минь , амийг минь авар! Төөтгөөхөн хүү би төө халзан бяруугаа өгье гэжээ. Хүү бяруугаа төхөөрөөд , цусыг нь олгойд хийж , чонын нүдийг хариулж байгаад , сэмхэн өвөртөлжээ. Бярууны махыг чоно нүд ирмэхийн зуур залгиж орхиод :

-Төөтгөөхөн минь, бярууны мах юу болох вэ дээ! Шүдний чигчлүүр ч болсонгүй. Одоо чамайг идэж, ов шуналаа дарна гээд ухасхийжээ. Төөтгөөхөн хүү айн сүрдэж , голын мөсөн дээгүүр гүйнгүүтээ халтирсан болоод , олгойтой цусаа хагалаад гоожуулжээ.

-Хүү чононд :

-Чоно гуай! Долоогоорой, долоогоорой , цус минь гоожлоо гэхэд ховдог чоно долоох гээд хэлээ мөсөнд наалдуулчихжээ.

-Хүү минь! Балт сүхээрээ хэл мөс хоёрын дундуур цавчаарай гэхэд:

-Аман хүзүү , хатан хүзүү хоёрын заагаар гэж хэлээд цавчжээ. Ингэж ухаант хүү аюулт чонын амнаас амьд мэнд гарч, амар сайхан жаргасан гэдэг.

**СОНГОХ ДААЛГАВАР**

1. “Гай газар доороос гахай модон дотроос” гэсэн хэлц үгэнд тохирох хэсгийг олоорой. / 1 оноо/

А. Гай тохиолдох      В. Айх      Б. Сандрах      Г. Гэнэтийн саад учрах

2. Хүү хаана олгойтой цусаа хагалсан бэ? / 1 оноо/

А. Ууланд      Б. Хадан дээр      В. Мөсөн дээр      Г. Голын усанд

3. Үлгэрийн төгсгөл хэсгийн үйл явдал юуны тухай өгүүлж байна вэ? / 1 оноо/

А. Хүү түлээ бэлдэхээр явсан.

Б.Хүү аюулт чонын амнаас амьд гарсан.

В. Хүү чононоос айсан.

Г. Төөтгөөхөн хүү бяруугаа төхөөрсөн.

4. Төөтгөөхөн хүү ямар зан чанартай вэ? / 1 оноо/

- А. Ууртай      Б. Харамч      В.Ухаантай      Г.Онгиороо

5. Эхийн үйл явдлын зөв дарааллыг сонгоно уу? / 1 оноо/

1. Хүү бяруугаа төхөөрөөд цусыг нь олгойд хийж чонын нүдийг хариулж байгаад сэмхэн өвөртөлжээ.

2. Чоно гуай! Долоогоорой, долгоорой цус минь гоожлоо гэхэд чоно долоох гээд хэлээ мөсөнд наалдуулчихжээ.

3. Ходоод гэдэс минь хоосон болохоор хоёр бөөр минь хонхос хонхос хийж байна.

- А. 3, 1, 2      Б. 1, 2, 3      В. 2, 3, 1      Г. 1, 3, 2

6. “сүрдэж” гэдэг үгийн балархай эгшиг ямар дүрмээр бичигдсэн байна вэ? / 1 оноо/

- А. ЭГ+ЗГ=-Э      Б.ЗГ+ЗГ=+Э      В. ЭГ+ЭГ=+Э

7. ....голын хөвөөгөөр модод ургасан байв. / 1 оноо/

- А. Туйл      Б. Тууль      В. Туул

8. Дараах үгсээс “хэлэх” гэсэн үгтэй ойролцоо утгатай үгийг олоорой. / 1 оноо/

- А. Сонсох      Б. Ярих      В. Бодох      Г. Хашгирах

9.Бярууны махыг чоно .....залгиж орхив. / 1 оноо/

- А. Нүд ирмэхийн зуур      Б. Борви бохис хийлгүй      В. Гараа хумхих

10. “.....” холбох үгээр нэг төрлийн үг, өгүүлбэрийг зэрэгцүүлэн холбодог. / 1 оноо/

- А. Бас, харин      Б. Яагаад гэвэл      В. Ба, бөгөөд      Г. Ийм учраас, цаашилбал

### ХОЁРДУГААР ХЭСЭГ: ЗАДГАЙ ДААЛГАВАР

1. Зохиолын баатрын дүр байдлыг төсөөлөн бичээрэй. \2 оноо\

	Төөтгөөхөн хүү
Гадаад дүр байдал	..... .....
Зан чанар	..... .....

2. Үгсийг ажиглан, дүрмийг гүйцээн бичээрэй. \үзье, хэлье, нисье, хүрье \ 3 оноо\

.....-ээр төгссөн .... үгэнд “е”-г залгахдаа өмнө нь “.....” бичнэ.

3. Хэрвээ чи Төөтгөөхөн хүүгийн оронд байсан бол яах байсан бол? Өөрийн бодлоо бичнэ үү? \2 оноо\

.....  
.....  
.....

4. “Нүд ирмэхийн зуур” хэлцийн утгыг тайлбарлан өгүүлбэр зохион бичээрэй. \2оноо\

.....  
.....  
.....

5. “Ховдог чоно” эхийг уншаад өөрт төрсөн сэтгэгдлээ 60-80 үгэнд багтаан илэрхийлэн бичээрэй. \5 оноо\

**Эхлэл хэсэг-** Эхийг уншихад сэтгэл чинь хэрхэн хөдөлсөн тухай бичээрэй. Бахархсан уу? Баярласан уу? Түгшсэн үү?

.....  
.....  
.....  
.....  
.....

**Гол хэсэг-**Хэрвээ чи Төөтгөөхөн хүүгийн оронд байсан бол яах байсан бол? Өөрт тохиолдсон явдлаар жишээ татаж бичээрэй.

.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....

**Төгсгөл хэсэг-** Эхээс юу ухаарсан, бусдад хандаж хэлэх үгээ бичээрэй.

.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....

ДОРНОД АЙМГИЙН 8 ДУГААР СУРГУУЛИЙН 4 ДҮГЭЭР АНГИЙН **МОНГОЛ ХЭЛ  
ХИЧЭЭЛИЙН ШАЛГАЛТЫН СЭДЭВ**

**НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. УНШИХ**

**Б ХУВИЛБАР**

**Ховдог чоно**

Төөтгөөхөн хүү төө халзан бяруугаа унаад , балт сүхээ бүсэндээ хавчуулаад, түлээ бэлдэхээр ойн захад очжээ. Гэтэл гай газар доороос гахай модон дотроос гэгчээр өлөн чоно гарч ирээд:

- Ходоод гэдэс минь хоосон болохоор хоёр бөөр минь хонхос хонхос хийж байна. Чамайг иднэ гэжээ.

- Ачит буурал чоно гуай минь , амийг минь авар! Төөтгөөхөн хүү би төө халзан бяруугаа өгье гэжээ. Хүү бяруугаа төхөөрөөд , цусыг нь олгойд хийж , чонын нүдийг хариулж байгаад , сэмхэн өвөртөлжээ. Бярууны махыг чоно нүд ирмэхийн зуур залгиж орхиод :

-Төөтгөөхөн минь, бярууны мах юу болох вэ дээ! Шүдний чигчлүүр ч болсонгүй. Одоо чамайг идэж, ов шуналаа дарна гээд ухасхийжээ. Төөтгөөхөн хүү айн сүрдэж , голын мөсөн дээгүүр гүйнгүүтээ халтирсан болоод , олгойтой цусаа хагалаад гоожуулжээ.

-Хүү чононд :

-Чоно гуай! Долоогоорой, долоогоорой , цус минь гоожлоо гэхэд ховдог чоно долоох гээд хэлээ мөсөнд наалдуулчихжээ.

-Хүү минь! Балт сүхээрээ хэл мөс хоёрын дундуур цавчаарай гэхэд:

-Аман хүзүү , хатан хүзүү хоёрын заагаар гэж хэлээд цавчжээ. Ингэж ухаант хүү аюулт чонын амнаас амьд мэнд гарч, амар сайхан жаргасан гэдэг.

**СОНГОХ ДААЛГАВАР**

1. “ Нүд ирмэхийн зуур” гэсэн үгийн утгад тохирох хэсгийг олоорой. / 1 оноо/

А.Нүдээ аних

Б. Нүдээ ирмэх

В. Маш хурдан

2. Хүү хэзээ, хаана олгойтой цусаа хагалсан бэ?

А. Өвөл, мөсөн дээр

Б. Зун , ойд

В. Зун, гол дээр

Г. Өвөл, ойд

3. Үлгэрийн төгсгөл хэсгийн үйл явдал юуны тухай өгүүлж байна вэ? / 1 оноо/

А. Хүү балт сүхээ аваад ой руу явсан.

Б. Хүү чононоос маш их айсан

В. Ухаант хүү аюулт чононоос өөрийгөө аварсан

Г. Төөтгөөхөн хүү бяруугаа төхөөрсөн

4. Төөтгөөхөн хүү ямар зан чанартай вэ? / 1 оноо/  
 А. Ууртай      Б. Харамч      В.Ухаантай      Г.Онгиороо
5. Эхийн үйл явдлын зөв дарааллыг сонгоно уу? / 1 оноо/  
 Эхийн үйл явдлын зөв дарааллыг сонгоно уу?
1. Аман хүзүү, хатан хүзүү хоёрын заагаар гэж хэлээд цавчжээ.
  2. Гай газар доороос гэгчээр өлөн чоно гарч ирээд:
  3. Төөтгөөхөн минь, бярууны мах юу болох вэ дээ? Шүдний чигчлүүр ч болсонгүй.  
 А.3,2,1                                      Б.2,3,1                                      В.1,3,2
6. “балт” гэдэг үгийн дүрэмд тохирох загварыг олоорой. / 1 оноо/  
 А. ЭГ+ЗГ=-Э      Б.ЗГ+ЗГ=+Э      В. ЭГ+ЭГ=+Э
7. Нүүхдээ гэрийн.....сайн цэвэрлэх хэрэгтэй. / 1 оноо/  
 А. бууриа      Б. буураа      В. буйраа
8. Дараах үгсээс “ховдог” гэсэн үгтэй ойролцоо утгатай үгийг олоорой. / 1 оноо/  
 А. цатгалан      Б. идэмхий      В. өлсгөлөн      Г. Их иддэг
9. Бярууны махыг чоно .....залгиж орхив. / 1 оноо/  
 А. Нүд ирмэхийн зуур      Б. Борви бохис хийлгүй      В. Гуяа ганзагалах
10. “.....” холбох үгс нь өгүүлбэр, цогцолборыг холбоно. / 1 оноо/  
 А. Бас, харин      Б. Ба      В. Бөгөөд      Г. Яагаад гэвэл

**ХОЁРДУГААР ХЭСЭГ: ЗАДГАЙ ДААЛГАВАР**

1. Зохиолын баатрын дүр байдлыг төсөөлөн бичээрэй. \2 оноо\

	Төөтгөөхөн хүү
Гадаад дүр байдал	..... .....
Зан чанар	..... .....

2.Үгсийг ажиглан, дүрмийг гүйцээн бичээрэй.**Явъя, очъё, авъя, уръя**\3 оноо\  
 .....-ээр төгссөн ..... үгэнд “я, ё”-г залгахдаа өмнө нь “.....” бичнэ.

3. Хэрвээ чи Төөтгөөхөн хүүгийн оронд байсан бол яах байсан бол? Өөрийн бодлоо бичнэ үү? \2 оноо\

.....  
.....  
.....

4. “Гай газар дотроос, гахай модон дотроос” хэлцийн утгыг тайлбарлан өгүүлбэр зохион бичээрэй. \2 оноо\

.....  
.....  
.....

5. “Ховдог чоно” эхийг уншаад өөрт төрсөн сэтгэгдлээ 60-80 үгэнд багтаан илэрхийлэн бичээрэй. \5 оноо\

**Эхлэл хэсэг-** Эхийг уншихад сэтгэл чинь хэрхэн хөдөлсөн тухай бичээрэй. Бахархсан уу? Баярласан уу? Түгшсэн үү?

.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....

**Гол хэсэг-**Хэрвээ чи Төөтгөөхөн хүүгийн оронд байсан бол яах байсан бол? Өөрт тохиолдсон явдлаар жишээ татаж бичээрэй.

.....  
.....  
.....  
.....  
.....

**Төгсгөл хэсэг-** Эхээс юу ухаарсан, бусдад хандаж хэлэх үгээ бичээрэй.

.....  
.....  
.....  
.....  
.....

Монгол хэл хичээлийн “Ховдог чоно” сэдвийн шалгалтын хариу

Сонгох даалгавар				
А			Б	
№	Зөв хариу	оноо	Зөв хариу	оноо
1	Г	1	В	1
2	В	1	А	1
3	Б	1	В	1
4	В	1	В	1
5	А	1	Б	1
6	Б	1	А	1
	В	1	А	1
8	Б	1	Б	1
9	А	1	А	1
10	В	1	А	1
Задгай даалгавар				
1	Гадаад дүр байдал 1 оноо Зан чанар 1 оноо нийт 2 оноо	2	Гадаад дүр байдал 1 оноо Зан чанар 1 оноо нийт 2 оноо	2
2	Гийгүүлэгчээр, эм, ь тэмдэг гэж бичсэн үг тус бүр 1 оноо нийт 3	3	Гийгүүлэгчээр, эр, ь тэмдэг гэж бичсэн үг тус бүр 1 оноо нийт 3	3
3	Өөрийн бодол санаагаа илэрхийлэн бүрэн ойлгомжтой бичсэн бол 2 оноо Өөрийн бодол санаагаа дутуу илэрхийлэн бичсэн бол 1 оноо	2	Өөрийн бодол санаагаа илэрхийлэн бүрэн ойлгомжтой бичсэн бол 2 оноо Өөрийн бодол санаагаа дутуу илэрхийлэн бичсэн бол 1 оноо	2
4	Нүд ирмэхийн зуур-маш хурдан Хэлцийн утгыг тайлбарлан бичсэн бол 1 оноо Өгүүлбэрт оруулан зохион бичсэн бол 1 оноо нийт 2 оноо	2	Гай газар дороос гахай модон дотроос-гэнэтийн саад учрах Хэлцийн утгыг тайлбарлан бичсэн бол 1 оноо Өгүүлбэрт оруулан зохион бичсэн бол 1 оноо нийт 2 оноо	2
5	Төрсөн сэтгэгдлээ илэрхийлсэн бол - 3 оноо /Үгийн тоо -1 оноо/ Зөв бичих 1 оноо /алдсан үг бүрээс 0, 1оноо хасна / Нийт 5 оноо	5	Төрсөн сэтгэгдлээ илэрхийлсэн бол - 3 оноо Үгийн тоо -1 оноо Зөв бичих 1 оноо /алдсан үг бүрээс 0, 1оноо хасна / Нийт 5 оноо	5
<b>Нийт 24 оноо</b>				



